



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2019 оны 1 дүгээр сар

Ерөнхий тойм: Энэ оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 42%-иар буюу 326 сая ам.доллараар өсч 1,111 сая ам.доллар байв. Үүнд экспорт 43%-иар буюу 183 сая ам.доллараар, импорт 40%-иар буюу 143 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 41 сая ам.доллараар өсч 103 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 1 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	706	785	1,111	79	11%	326	42%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	429	424	607	(5)	-1%	183	43%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	277	361	504	84	30%	143	40%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	151	63	103	(89)	-59%	41	65%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 47 сая ам.доллараар өсч 124 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 55% буюу 612 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 13% буюу 146 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 14%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 27%-иар тус тус өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.8%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 0.8%-иар буурч 1.741-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад зэсийн баяжмалын экспортын үнийн бууралт голлон нөлөөлөв.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 43%-иар буюу 183 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 42 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.8 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		393	92%	378	89%		554	91%		(15)	-4%	-4%	176	47%	42%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	134	137	32%	97	127	30%	117	157	26%	(10)	-7%	-2%	30	24%	7%
1.2. Чулуун нүүрс	2,592	168	39%	1,926	136	32%	2,118	169	28%	(33)	-19%	-8%	33	25%	8%
1.3. Боловсруулаагүй нефть	593	31	7%	555	35	8%	534	27	4%	4	13%	7%	(8)	-22%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	260	15	4%	437	18	4%	609	26	4%	2	16%	7%	8	48%	2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	467	18	4%	622	27	6%	3,110	130	21%	9	49%	2%	103	379%	24%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	9	12	3%	11	19	5%	12	17	3%	7	61%	2%	(2)	-12%	-7%
1.7. Жонош, лейцит, нефелинт	19	4	1%	29	9	2%	54	18	3%	5	108%	7%	8	92%	2%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	0	2	0%	0	3	1%	0	4	1%	1	51%	0%	1	48%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	-	0%	0	0	0%	0	0	0%	0	0%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	-	0%	0	0	0%	0	-	0%	0	0%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	46	5	1%	74	4	1%	47	5	1%	(1)	-20%	0%	1	26%	0%
2. Мал аж, ахуй	48	16	4%	59	20	5%	42	24	4%	4	22%	1%	4	20%	1%
2.1. Амьд мал, малын мах	1	2	1%	4	9	2%	4	8	1%	6	270%	7%	(0)	-2%	0%
2.2. Арьс, шир	45	4	1%	53	3	1%	35	1	0%	(1)	-25%	0%	(2)	-55%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	-	0%	0	0	0%	0	0	0%	0	0%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	1	9	2%	1	7	2%	1	10	2%	(2)	-24%	0%	3	41%	7%
2.5. Ноос, бусад үс, хялгас	0	1	0%	1	1	0%	2	4	1%	0	61%	0%	3	215%	7%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	20%	0%	0	18%	0%
3. Газар тариалан	1	1	0%	0	0	0%	8	2	0%	(0)	-74%	0%	2	1059%	0%
4. Аж үйлдвэрлэл	27	18	4%	6	25	6%	39	27	4%	7	40%	2%	1	5%	0%
4.1. Хүнс	1	5	1%	3	11	3%	6	15	2%	6	120%	7%	3	29%	7%
4.2. Ноолууран адал	0	1	0%	0	2	0%	0	2	0%	0	7%	0%	1	42%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, адал	0	1	0%	0	1	0%	0	1	0%	0	43%	0%	(0)	-31%	0%
4.4. Уул уурхай	2	8	2%	2	9	2%	4	6	1%	1	10%	0%	(3)	-28%	-7%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	365%	0%	0	3%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	0	2	1%	0	2	0%	0	2	0%	(0)	-20%	0%	1	29%	0%
4.7. Бусад	23	0	0%	0	1	0%	29	0	0%	0	61%	0%	(0)	-24%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-27%	0%	(0)	-48%	0%
Нийт дүн		429		424			607			(5)	-1%		183	43%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)


Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2019 оны 1 дүгээр сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	%	%	%	%
1. Уул уурхай	159		17		176	47%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	27	88%	4	12%	30	24%
1.2. Чулуун нүүрс	15	46%	18	54%	33	25%
1.3. Боловсруулаагүй нефть	(1)	15%	(6)	85%	(8)	-22%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	7		1		8	48%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	104	101%	(1)	-1%	103	379%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	1	-53%	(4)	153%	(2)	-12%
1.7. Жонош, лейцит, нефелинт	8	96%	0	4%	8	92%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	0	14%	1	86%	1	48%
1.11. Бусад	(3)	-273%	4	373%	1	26%
2. Мал аж, ахуй	4		0		4	20%
2.1. Амьд мал, малын мах	1	-320%	(1)	420%	(0)	-2%
2.2. Арьс, шир	(1)	43%	(1)	57%	(2)	-55%
2.3. Малын өлөн гэдэс	0	100%	0	0%	0	0%
2.4. Ноолуур	1	39%	2	61%	3	41%
3. Газар тариалан	2		(0)		2	12x
4. Аж үйлдвэрлэл	3		(2)		1	5%
5. Бусад	0		(0)		(0)	-48%
Нийт дүн	168		15		183	43%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2019 оны 1 дүгээр сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 168 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 15 сая ам.доллараар өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 42 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 22 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 3 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 2 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 1 дүгээр сард 1,293 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9%-иар буурсан хэдий ч өнгөрсөн сараас 3.2%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,939; 76 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 15.9%-иар, төмрийн хүдэр 0.2%-иар, өнгөрсөн сараас зэс 2.2%-иар тус тус буурсан бол төмрийн хүдэр 10.1%-иар өссөн. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 1 дүгээр сард 80 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 13.3%-иар, өмнөх сараас 13.5%-иар тус тус өслөө.

Импорт 2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар буюу 143 сая ам.доллараар өсөв. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 24 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 9 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		86	31%		111	31%		139	28%	25	29%	9%	28	25%	8%
Түргэн эдэлгээтэй	71	49	18%	68	59	16%	80	63	13%	9	19%	3%	5	8%	1%
Хүнс	23	31	11%	33	41	11%	34	44	9%	10	33%	4%	3	7%	1%
Эм, тариа	0	8	3%	0	7	2%	0	6	1%	(1)	-10%	0%	(1)	-12%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	48	10	4%	35	10	3%	45	13	3%	(0)	-1%	0%	3	25%	1%
Удаан эдэлгээтэй	34	37	13%	14	53	15%	21	76	15%	16	42%	6%	24	45%	7%
Гутал, хувцас, цунх	6	4	2%	5	5	1%	7	5	1%	1	20%	0%	0	4%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	19	10	4%	4	10	3%	6	11	2%	0	3%	0%	1	7%	0%
Авто машин, түүний салбэр хэрэгсэл	0	19	7%	0	32	9%	0	54	11%	13	66%	5%	22	70%	6%
Бусад удаан эдэлгээтэй бараа	8	4	1%	4	6	2%	7	6	1%	2	45%	1%	1	10%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	76	95	34%	110	122	34%	108	207	41%	26	28%	10%	85	70%	24%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	3	72	26%	1	81	22%	2	158	31%	9	13%	3%	77	95%	21%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	9	3%	0	16	4%	1	63	13%	7	80%	2%	48	309%	13%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	3	63	23%	1	66	18%	2	94	19%	2	4%	1%	29	44%	8%
Барилгын материал	17	14	5%	22	25	7%	37	36	7%	11	80%	4%	10	42%	3%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	3	9	3%	3	16	4%	2	14	3%	6	64%	2%	(2)	-11%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	103	37	13%	114	52	15%	176	50	10%	16	42%	6%	(2)	-4%	-1%
Хүнсний орц	4	1	0%	29	7	2%	3	1	0%	5	403%	2%	(5)	-79%	-1%
Химийн бүтээгдэхүүн	10	6	2%	16	8	2%	15	8	2%	2	35%	1%	0	1%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	2	2	1%	4	2	1%	6	3	1%	0	26%	0%	1	41%	0%
Цахилгаан эрчим хүч	0	10	4%	0	12	3%	0	10	2%	2	16%	1%	(2)	-19%	-1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-61%	0%	0	156%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	61	17	6%	61	23	6%	84	28	6%	6	35%	2%	5	20%	1%
Нефтийн бүтээгдэхүүн	103	58	21%	114	75	21%	176	106	21%	17	29%	6%	31	42%	9%
Дизель түлш	68	36	13%	81	51	14%	106	66	13%	15	43%	5%	15	30%	4%
АИ-92, АИ-95	26	15	6%	24	16	4%	51	28	6%	0	3%	0%	13	79%	3%
А-80 болон бусад	9	7	3%	9	8	2%	18	12	2%	1	18%	0%	4	46%	1%
Бусад	2	1	0%	2	1	0%	11	1	0%	0	6%	0%	(0)	-7%	0%
Нийт дүн		277		361			504			84	30%		143	40%	

²% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2019 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	33	118%	(5)	-18%	28	25%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	79	93%	6	7%	85	70%
Аж үйлдвэрлэлийн орц	(8)		6		(2)	-4%
Нефтийн бүтээгдэхүүн	37	118%	(6)	-18%	31	42%
Дизель түлш	16	104%	(1)	-4%	15	30%
АИ-92, АИ-95	15	123%	(3)	-23%	13	79%
А-80 болон бусад	6	158%	(2)	-58%	4	46%
Бусад	1		(1)		(0)	-7%
Нийт дүн	142	100%	1	0%	143	40%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 85 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 31 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 28 сая ам.доллараар өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 2 сая ам.доллараар буурснаар нийт импорт 143 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8 хувиар, өмнөх сараас 18 хувиар буурч тонн тутамд 605 ам.долларт хүрэв.